

1. Журмын холбогдох заалтуудыг дараах байдлаар өөрчилсүгэй.

1.1. журмын 2.2-р заалтыг

Хөдлөх бүрэлдэхүүн түрээсээр авч байгаа тохиолдолд дараах нөхцлийг хангасан байвал зохино.

2.2.1. түрээсээр авч байгаа вагон, хөдлөх бүрэлдэхүүн нь 2.1.1-т заасан бүх шаардлагыг хангасан байна.

2.2.2. Монгол Улсын төмөр замын тээвэрт түрээсээр ашиглагдах хөдлөх бүрэлдэхүүний түрээсийн хугацаа нь үндэсний стандартад заасан дунд засварын хугацаанаас хэтрэхгүй байна.

2.2.3. Дунд засварын хугацааг тооцохдоо тухайн вагонд засвар хийсэн байгууллагын эрх, хүлээн зөвшөөрөгдсөн тэмдэглэгээг үндэслэнэ.

2.2.4. Монгол улсын хилээр гаргах үед түрээслэгч нь төмөр замын газарт вагоныг буцаасан тухай заавал мэдэгдэж бүртгэл мэдээллээс хасуулах үүрэгтэй.

2.2.5. Монгол Улсын хилээр шинээр оруулан ирж төмөр замын тээвэрт ашиглах хөдлөх бүрэлдэхүүний техникийн нөхцөл, шаардлага, дугаарлалт, тэмдэг, тэмдэглэгээ нь энэхүү журамд заасан баримт бичгийн шаардлагыг хангасан байна. Мөн тухайн улсын нутаг дэвсгэрт худалдан авах болон түрээслэх хөдлөх бүрэлдэхүүнд хийсэн техникийн үзлэг, акт дүгнэлтийг ирүүлсэн байна.

1.2. журмын 3.2.7-р заалтыг

Хилээр нэвтрэх нийт хөдлөх бүрэлдэхүүний томьёолсон уртаар бүрэн багтах хэмжээний ашигтай уртыг илэрхийлэх өөрийн эзэмшлийн салбар замуудын гэрчилгээ эсхүл салбар зам эзэмшигч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ.

1.3. журмын 4.1-р заалтыг

Хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх эзэмших эрх болон улсын бүртгэлд бүртгэх, дугаар олгох, мэдээллийн сан байгуулах ажлыг Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох үндэсний стандартад нийцүүлэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

1.4. журмын 4.2-р заалтыг

Төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 3.3-т заасан дүгнэлт, шийдвэрийг үндэслэн импортоор оруулж ирсэн хөдлөх бүрэлдэхүүнд үндэсний стандартын дагуу дугаар, өмчлөгч эзэмшигчийн код, улсын бүртгэлд бүртгүүлж, хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээ олгоно.

1.5. журмын 4.3-р заалтыг

Бүх төрлийн санхүүгийн түрээсээр эзэмшиж буй хөдлөх бүрэлдэхүүнд зөвхөн түрээслэгчийн код олгож, мэдээллийн санд бүртгэнэ.

2. Журамд дараах заалтуудыг нэмэлтээр оруулсугай.

2.1. журмын 2.8-р заалтаар

Шаардлагатай тохиолдолд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тодорхой хугацаанд хэсэгчлэн хязгаарлалт хийж болно.

2.2. журмын 4.11-р заалтаар

Хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээг энэхүү журмын хавсралтаар баталж, 3.3-т заасан дүгнэлт болон холбогдох баримт бичгийг үндэслэн төрийн захиргааны байгууллага олгоно.

2.3. журмын 4.12-р заалтаар

Хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээ нь үйлдвэрлэгчээс тогтоосон ашиглалтын хугацаагаар олгоно.

оОо